

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

**Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

/Соёл, урлагийн салбарт хамаарах заалтуудын биелэлт/

2024.05.24

Дархан-Уул аймаг

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	үнэлгээ
Нэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд						
1.1	Дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Жилдээ	Соёл, урлагийн газар	Соёлын байгууллагууд, эцэг эхийн зөвлөл	Аймгийн Соёл, урлагийн газар болон харьяа соёлын 7 байгууллага нь тус төлөвлөгөөнөөс соёлын салбарт хамаарах 4 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	95%
1.2	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор холбогдох дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлуулж, мөрдөх	Жилдээ	Соёл, урлагийн газар	Соёлын байгууллагууд, Гэр бүл, хүүхэд хамгааллын газар, байгууллагын эцэг эхийн зөвлөл	-Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг таниулан сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулав. -Соёлын байгууллага бүр дэргэдээ “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль, тогтоомжийг судалж сурталчлан таниулах зорилгоор “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд 2024 нийтдээ 62 арга хэмжээг төлөвлөснөөс дараах ажлуудыг зохион байгуулаад байна. Тухайлбал: 1. Соёлын байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-өөс 108 хүүхдийн тусламжийн утсыг таниулах, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, бүх хэлбэрийн хүчирхийлэл дарамт, эрсдэлийг илрүүлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор нийтдээ 12 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.	100%

				<p>2. Соёлын байгууллагуудын ажиллагсдын 187 хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. Үүнээс 86 хүүхэд цэцэрлэгт хүмүүжиж, 101 хүүхэд ерөнхий боловсрол эзэмшихээр суралцаж байна.</p> <p>3. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нь өөрчлөлт оруулж, цэцэрлэгийн болон сургуулийн бага насны хүүхдээ хүргэж өгөх, авах нөхцөлөөр хангаж ажилтнуудын нийгмийн баталгааг хангасан.</p> <p>4. 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр цалинтай чөлөө олгож, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг оролцох боломжоор хангаж тогтмолжуулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 36 эцэг, эхэд чөлөө олгожээ.</p> <p>5. “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах нь” сэдэвт танхимын сургалтад соёлын салбарын 16 ажилтанг хамруулж, тэдний мэргэжил, арга зүйн ур чадвараа тасралтгүй дээшлүүлж байх таатай нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>6. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн урлагийн тоглолтыг 16 удаа зохион байгуулж, 4400 хүүхдийг хамруулав.</p> <p>7. Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгийг 2 дахь жилдээ зохион байгуулж 435 сурагчийг оролцуулав.</p> <p>8. “Нэгдүгээрт хүүхэд” аяны хүрээнд 3 сумдын соёлын төвийн дэргэд 7 дугуйлан хичээллэж 161 хүүхэд, Залуучууд театрын дэргэдэх 11 дугуйланд 108, нийт 269 хүүхэд хамрагдан суралцжээ.</p> <p>9. ХЭҮК-ийн Дархан-Уул аймаг дахь референт Э.Болортуяа нь Төв номын санд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” сэдвээр сургалт зохион байгуулж, ЕБС-ийн 24 сурагчийг хамруулсан байна.</p>	
--	--	--	--	---	--

					<p>10. Төв номын сан нь хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ХГБХХГ-тай хамтран “Харилцаа ба ёс суртахуун” сэдэвт сургалтад 90 гаруй багш, сурагч, ажилтан, албан хаагчдыг хамруулж, соён гэгээрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулжээ.</p> <p>11. Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс гэр бүл, хүүхэд, хамгааллын чиглэлээр 4 арга хэмжээг зохион байгуулсан байна.</p>	
<p>Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах хүрээнд</p>						
2.4	<p>Бүх шатны боловсролын байгууллага, соёлын төв, номын сангийн мэдээллийн самбар, цахим хуудаст хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас, богино хэмжээний шторк, сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулах</p>	Жилдээ	Соёл, урлагийн газар	Соёлын байгууллагууд, Гэр бүл, хүүхэд хамгааллын газар, эцэг эхийн зөвлөл	<p>-Тус газрын болон харьяа соёлын байгууллагуудын цахим хуудас болон мэдээллийн самбарт хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас 5, электрон тамхины хор уршгаас сэргийлэх талаар 4, цахим халдлагаас сэргийлэх зөвлөмж 5, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж 4, хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж 8, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аян” сэдэвт 12 зурагт хуудас, уриалга, 23 шторк сурталчилгааг байршуулж олон нийтэд сурталчиллаа.</p> <p>-Тус газар нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны 4 цэгт камер суурилуулж аюулгүй байдлаа ханган ажиллаж байна. Үүний үр дүнд шөнийн цагаар байгууллагын ойролцоо үйлдэгдсэн 1 гэмт хэргийг илрүүлэхэд хууль хяналтын байгууллагад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-Соёл, урлагийн байгууллагууд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, соён гэгээрүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 214 хүнийг танхимаар 214 хүнийг, цахимаар 12890 хүнийг хамруулсан байна. Үүнд:</p> <p>1.Аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан “Цахим гэмт хэргээс хүүхдээ хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх” сургалтад соёлын салбарын 25 албан хаагч хамрагдсан.</p>	98%

					<p>2. “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтад соёлын салбарын 22 ажилтан хамрагдсан.</p> <p>3. Хонгор сумын Соёлын төв нь сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран ЕБС-ийн сурагчдын дунд “Зөвийг үлгэрлье” видео бичлэгийн уралдаан зарлаж, 9 бүтээл ирснээс шилдэг 3 бүтээлийг шалгаруулж шагнаж урамшуулав.</p> <p>4. “Хүүхдээ сонсьё” цахим сургалтад соёлын байгууллагын 48 албан хаагчийг хамрууллаа.</p> <p>5. Аймгийн Цагдаагийн газартай хамтран “Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт”, “Цахим гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” лекцийг зохион байгуулж 20 хүнийг хамруулжээ.</p>	
Тав. Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:						
5.1	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэж буй аливаа контентуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэж түгээх</p>	Жилдээ	Соёл, урлагийн газар	Соёлын байгууллагууд, эцэг эхийн зөвлөл	<p>-Аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, СББӨ-ийг өвлөн уламжлагчид тус аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо” ТББ-тай хамтран 2024 оны 03 дугаар сараас эхлэн 18 хүртэлх насны 129 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд 6 удаа соёлын боловсролын хөтөлбөрөөр үйлчилсэн.</p> <p>-Номын сангийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ялгаваргүйгээр тэгш хүргэх, уншигчдад тохирсон дэд бүтэц, орчин нөхцөлийг бүрдүүлэх, номын баяжилт, техник хэрэгслээр хангаж хүртээмжийг сайжруулах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсны үр дүнд Төв номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан техник тоног төхөөрөмжийн төслийг орон нутгийн 60 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр болов. Тус хэлэлцүүлэгт СУГ, Төв номын сан, ХЭҮК-ийн Дархан-Уул аймаг дахь салбар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг, эхийн холбоо болон бусад холбоод, иргэдийн төлөөлөл нийт 24 хүн оролцов.</p>	97%

					-Соёл, урлагийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд соёлын байгууллагууд түр хамгаалах байр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, “Урам төв”-тэй хамтран соёлын боловсролын 19 хөтөлбөрийг 109 удаа зохион байгуулж 5402 хүнд хүрч үйлчилсэн.	
5.5	Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулах	IV улиралд	Соёл, урлагийн газар	Соёлын байгууллагууд	-Соёл, урлагийн байгууллагууд нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” хүрээнд 2024 онд 53 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. -Соёлын байгууллагууд “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д нэгдэж цахимаар 9, танхимаар 2 арга хэмжээг зохион байгуулсан. -“Жендэрийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтад 28 албан хаагч хамрагдсан.	90%
Дундаж үнэлгээ						96%

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ